



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан<sup>1</sup>)

### ХАМТРАН ЗЭЭЛДЭГЧ НЬ ТУХАЙН ЗЭЭЛИЙГ АШИГЛАСАН ЭСЭХЭЭС ҮЛ ХАМААРАН ҮНДСЭН ЗЭЭЛДЭГЧИЙН АДИЛ ҮҮРЭГ ХҮЛЭЭНЭ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 001/ХТ2025/00140

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

**Шийдвэрийн төлөв:** Хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч “Т” ХК нь хариуцагч М.Я-д холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт 17,205,373 төгрөг гаргуулах нэхэмжлэл гаргасан ба үндэслэлээ “...Н.Г, М.Я нартай 2013 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 248 дугаартай зээлийн гэрээ байгуулж, 14,000,000 төгрөгийг жилийн 12 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай олгосон. Уг гэрээний үүрэгт Н.Г-н өмчлөлийн \*\*\*\*\*1 тоот хаягт байршилтай, үл хөдлөх эд хөрөнгө, мөн хаягт байршилтай өмчлөх эрхтэй газрыг тус тус барьцаалсан. Н.Г 2015 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүнд өвчний улмаас нас барсан тул хамтран зээлдэгч М.Я-с нэхэмжилж байна” гэжээ.

Харин хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “...Тухайн зээлийг би хувьдаа ашиглаагүй, Н.Г өөрийн бизнестээ зарцуулсан, би төлбөрийн чадваргүй болсон тул зээлийн үүргийг хариуцахгүй, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах ёстой” хэмээн маргажээ.

### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх** нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэхдээ; “... Талуудын хооронд ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1 дэх хэсэгт<sup>2</sup> заасан гэрээ байгуулагдсан, гэрээ хүчин төгөлдөр, хариуцагч М.Я

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

[https://shuukh.mn/single\\_case/10886?daterange=2025-02-01%20-%202026-03-12&id=3&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/10886?daterange=2025-02-01%20-%202026-03-12&id=3&court_cat=1&bb=1)

<sup>2</sup> Иргэний хууль (2002)-ийн 451 дүгээр зүйлийн 451.1. “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын



хамтран зээлдэгчээр гарын үсэг зурсан, үндсэн зээлдэгч Н.Г нас барсан тул хамтран зээлдэгчээс үүргийн гүйцэтгэлийг шаардах нь хуульд заасан үндэслэл бүхий байна. ... даатгалын нөхөн төлбөрийг Ч.Ч шүүхийн шийдвэрээр өөртөө авсан бөгөөд шийдвэрийг хэрэгт хавсаргасан, нэр дээрх үл хөдлөх эд хөрөнгө зэрэг нь ээж, дүү нарынх нь эзэмшилд байгаа гэж хариуцагч маргасан боловч хариуцагчийн тайлбарыг үндэслэн зээлийн үүргээс чөлөөлөх нь хуульд нийцэхгүй тул нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх үндэслэлтэй.” гэж дүгнэсэн.

2. **Давж заалдах шатны шүүх** анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ: ...Өмнө нь анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр М.Я-н зээлийн гэрээний үүргийг хүлээх хэмжээг тогтоосон байхад бүхэлд нь гаргуулж шийдвэрлэсэн нь ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт<sup>3</sup> заасантай нийцэхгүй, ... Н.Г-н ээж Ч.Ч зээлийн гэрээний үүргийг даатгалын гэрээний дагуу шаардаж авсан атлаа нэхэмжлэгч байгууллагад төлөөгүй байхад нэхэмжлэгч М.Я-с зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь шаардаж байгаа нь ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.3 дахь хэсэгтэй<sup>4</sup> нийцэхгүй, ... М.Я гэрээний үүргийг өөрт ногдох хэмжээгээр хариуцна, ... ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.9 дэх хэсэгт<sup>5</sup> зааснаар зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд мөнгөн хөрөнгө гаргуулах тухай шаардлагыг ногдох хэсгээр хуваан шаардаж болох тул Ч.Ч нь өвтэй тэнцүү хэмжээгээр үүрэг хүлээнэ ...” гэсэн дүгнэлтийг хийжээ.
3. **Хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ** талуудын хооронд байгуулагдсан зээлийн гэрээний агуулга, нөхцөлөөс үзвэл зээлдэгч нар нэг ашиг сонирхолтой, хэн аль нь зээлдүүлэгч буюу “Т” ХК-ийн өмнө үүрэг гүйцэтгэх, нэхэмжлэгч “Т” ХК нь зээлдэгч нарын хэн алинаас нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй тул ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.1 дэх хэсэгт<sup>6</sup> зааснаар хариуцагч М.Я-г хамтран үүрэг гүйцэтгэгч буюу хамтран зээлдэгч гэж үзнэ. Нэгэнт **хариуцагч хамтран зээлдэгч тул нэхэмжлэгч нь ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.3 дахь хэсэгт зааснаар үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй, хариуцагч нь зээлийн гэрээний холбогдох заалт болон ИХ-**

---

дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

<sup>3</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)-ийн 40 дүгээр зүйлийн 40.4. “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй.”

<sup>4</sup> ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.3. “Үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үзэмжээр аль ч үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардаж болох бөгөөд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хүлээсэн үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна.”

<sup>5</sup> ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.9. “Хамтран үүрэг гүйцэтгэгч нэг этгээд хэд хэдэн өвлөгчтэй бол тэдгээр нь тус бүрдээ өв залгамжлалаар өөрт ногдох өвтэй хувь тэнцүү хэмжээгээр үүрэг хүлээх боловч шаардлага нь үл хуваагдах шинжтэй бол энэ журам хамаарахгүй.”

<sup>6</sup> ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.1. “Үүрэг гүйцэтгэгчдийн хэн хэн нь үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээлгэн өгөх, үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн үүрэг гүйцэтгэгч тус бүрээс шаардах эрх бүхий байвал хамтран үүрэг гүйцэтгэгчид гэнэ.”



- ийн 451 дүгээр зүйлийн 451.1, 453 дугаар зүйлийн 453.1 дэх хэсэгт<sup>7</sup> заасны дагуу үндсэн зээлийг хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хамт төлөх үүрэгтэй. (14)<sup>8</sup>
4. Гэтэл давж заалдах шатны шүүх зохигчийн хооронд байгуулсан гэрээ хүчин төгөлдөр гэж дүгнэсэн атлаа даатгалын гэрээний маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг “Т” ХК-ийн нэхэмжлэлтэй энэ хэрэгт тогтоогдсон үйл баримт гэж дүгнэсэн нь ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт нийцсэнгүй. Учир нь, ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримт иргэний өөр хэргийг шийдвэрлэхэд нотлогдсон гэж тооцох тухай зохицуулалт нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон этгээдийн хувьд өөр хэрэгт хэргийн оролцогчоор орж байгаа тохиолдолд нотлогдсон гэж үзэх бөгөөд тухайн өмнөх хэрэгт оролцоогүй этгээдийн хувьд хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримтын талаар өөр хэрэгт маргах эрхтэй буюу уг зохицуулалт үйлчлэхгүй. (15)
5. Мөн давж заалдах шатны шүүх “... М.Я гэрээний үүргийг өөрт ногдох хэмжээгээр хариуцна...” гэх дүгнэлт хийсэн нь ИХШХШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт<sup>9</sup> нийцээгүй, Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.1, 242.3-т заасныг буруу хэрэглэсэн байна. Учир нь, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Зээлийн гэрээний хугацаа дууссан нь тухайн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй зээлдэгчийг зээл, түүний хүү, нэмэгдүүлсэн хүүг төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй”, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Зээлдэгч зээлийг зээлийн гэрээнд заасны дагуу төлөөгүй...бол зээлийг бүрэн эргүүлэн төлөх хүртэлх хугацаанд зээлийн үндсэн хүү, зээлийн гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлнө.” гэж тус тус заасан ба талуудын хооронд байгуулсан гэрээний 3.2.3 дахь хэсэгт “зээл, зээлийн хүүгийн төлбөрийг ... төлөх”, 3.3.1 дэх хэсэгт “хамтран зээлдэгч нь зээлдэгчийн адил үүрэг хүлээх”-ээр харилцан тохиролцсон, үүний дагуу хариуцагч нь зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг төлж байсан үйл баримт тогтоогдсон. Хамтран зээлдэгч буюу хариуцагчийн хувьд энэ үүрэг нь хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуустал үргэлжилнэ. (16)
6. Нэхэмжлэгч “Т” ХК-ийн Н.Г, М.Я нартай байгуулсан барьцааны гэрээ хүчин төгөлдөр байх бөгөөд нэхэмжлэгч барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлага гаргаагүй. Барьцааны шаардлага нь хоёрдогч үүргийн шинжтэй тул үндсэн үүргийн шаардах эрх үүссэн, хэрэгжих боломжтой эсэх маргааныг шийдвэрлэхэд барьцаагаар үүрэг хангагдах эсэх нөхцөл байдал нөлөөлөхгүй. Үндсэн шаардлага байсан ч хожим барьцааны үүргээр шаардлага хэрэгжүүлэх эрхийг хөндөхгүй гэж дүгнэжээ. (18)

<sup>7</sup> ИХ-ийн 453 дугаар зүйлийн 453.1. “Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй.”

<sup>8</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

<sup>9</sup> ИХШХШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.5. “Шүүх бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдэд холбогдох асуудлыг үндсэн нэхэмжлэлийн хамт шийдвэрлэхгүй.”